



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2018 оны 9 сарын 05 өдөр

Дугаар 388

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга  
хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн “Монгол Кувейтын байгаль хамгаалах төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын 2016, 2017 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар нийт 303.8 сая төгрөгийн зөрчил, дутагдал илэрснийг тэмдэглээд ТОГТООХ нь:

1. “Монгол Кувейтын байгаль хамгаалах төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын 2016, 2017 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. “Монгол Кувейтын байгаль хамгаалах төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Ч.Батжаргалд дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг үүрэг болгосугай:

2.1. Үйлдвэрийн газрын эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшингийн төлөвлөгөөний биелэлтийг ханган ажиллаж, бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний өртөг, зардлын тооцооллыг нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу гүйцэтгэх;

2.2. Үйлдвэрийн газрын бүтэц орон тоог шинэчлэн баталж хүний нөөцийн оновчтой, чадварлаг баг бий болгох, байгууллагын баримт бичгийг хууль журамд заасны дагуу бүрдүүлэх;

2.3. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж, хөрөнгийн бүртгэл, хөтлөлт, тайлагналыг хууль журамд нийцүүлэх;

2.4. Авлага, өглөгийг тооцоо нийлж актаар баталгаажуулах, хариуцагч нь тодорхойгүй 53,2 сая төгрөгийн авлагыг шүүхийн журмаар шийдвэрлүүлэх, холбогдох албан тушаалтнаас нэхэмжилж авах, шаардлагатай бол хууль хяналтын байгууллагад хандах;

2.5. Үндсэн болон эргэлтийн хөрөнгийн тооллогыг нөхөн явуулж санхүүгийн тайланд зөрүүтэй илэрхийлэгдсэн 16,2 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн нэр, үнийн дүнг анхан шатны баримтыг үндэслэн эрх бүхий байгууллагын зөвшөөрлөөр залруулах, бүртгэлгүй хөрөнгийг үнэлж бүртгэлд тусгах, “Монгол Кувейтын судалгааны төв” төрийн бус байгууллагын нэр дээр байгаа 4 ширхэг автомашин, 10,1 га газрыг байгууллагын нэр дээр шилжүүлэн авах;

2.6. Байгууллага дээр мөрдөгдвөл зохих хууль эрхийн актууд түүний дотор эрхэлж байгаа үйл ажиллагааны чиглэлтэй уялдсан “Нийтлэг үйлчилгээний журам” боловсруулан, эрх бүхий байгууллагаар батлуулж, мөрдөх;

0002197



2.7. 2016 он, 2017 оны санхүүгийн тайлангийн программ хангамжийг алдаатай хөтөлсөн, бүрдэл дутуу баримтаар ажил гүйлгээ хийсэн, эзэн хариуцагчийн жагсаалтгүй авлага хүлээлгэн өгсөн, эрх бүхий байгууллагаас баталсан мэргэжлийн ёс зүйн дүрмийг зөрчсөн санхүүгийн ажилтанд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцох, хохирлыг барагдуулах арга хэмжээ авах;

2.8. Шалгалтын тайланд дурдсан зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх, биелэлтийг 2018 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА




Ц.НЯМ-ОСОР

Б.ГАВАА



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
 2018 оны 9 дугаар сарын 05-ны өдрийн  
 383 дугаар тогтоолын хавсралт



“Монгол Кувейтын байгаль хамгаалах төв”  
 төрийн өмчит үйлдвэрийн газарт хийсэн  
 шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг  
 арилгах арга хэмжээний жагсаалт

Д/д	Зөрчил, дутагдлын утга	Хариуцах нэгж	Мөнгөн дүн /сая төгрөгөөр/	Зөрчил, дутагдлыг арилгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ
1	Зөвшөөрөлгүй үндсэн хөрөнгө бэлтгэсэн	Захиргааны хэлтэс	12,7	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн дагуу үндсэн хөрөнгө олж авах
2	Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой зөрчил	Захиргааны хэлтэс	28,0	Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, олон улсын стандартыг мөрдөж ажиллах
3	Мөнгөн кассын үйл ажиллагаатай холбоотой зөрчил	Захиргааны хэлтэс	80,1	Мөнгөн кассын үйл ажиллагааны журмын зохицуулалтуудыг боловсруулан мөрдөх
4	Авлага, өглөгтэй холбоотой зөрчил	Захиргааны хэлтэс	78,0	Авлагыг хууль, шүүхийн байгууллагад шилжүүлж барагдуулах арга хэмжээ авах, тооцоо нийлсэн актаар баталгаажуулах
5	Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаатай холбоотой зөрчил	Захиргааны хэлтэс	105,0	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хууль, холбогдох журмыг мөрдөж хэрэгжүүлэх
	<b>Зөрчил, дутагдлын нийт дүн:</b>		<b>303,8</b>	